

2007 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААРХ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭГТГЭЛИЙН СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

2007.09.11

Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд Говийн цэнхэр алтай, Жи СИ Ай Пи, Финанс энд девелопмент оф майнинг, Зул оюу, Монголиагонконг финанс корпораци зэрэг 5 ХХК-уудад Хорооны тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, харин Мистермо кредит ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хорооны даргын 2007 оны 73 тоот тушаалаар хүчингүй болгосноор хоёрдугаар улирлын нэгтгэлд нийт 141 ББСБ хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын тоо 14.2 хувиар /*өмнөх оны мөн үед 161 ББСБ*/ буурсан байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаануудыг ББСБ-уудын эрхэлж буй төрлөөр нь ангилж үзэхэд давхардсан тоогоор зээлийн үйл ажиллагаа 138, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа 54, итгэлцлийн үйл ажиллагаа 12 /*Дельта сан, Транскапитал*/, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа 16 /*Монгол лизинг, Дельта сан, Би энд Жи финанс*/, факторингийн 3 /*Ийст Уэст факторинг*/, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 12 /*Мөнгөн гүүр, Шинэ төгрөг, Кредит монгол*/, санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээг 2 /*Хөгжил эх*/ ББСБ тус тус дангаар буюу нэмэлт тусгай зөвшөөрлөөр эрхэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудын тоо 28 байгаа нь нийт банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 19.9 хувийг, тэдгээрийн нийт актив 2,030.5 сая төгрөгт хүрсэн нь нийт ББСБ-уудын активын 2.9 хувийг эзэлж байна./*Хавсралт II*

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-дын байршлын хувьд авч үзвэл Дорнод аймагт 7, Дархан-Уул, Орхон аймагт тус бүр 3, Завхан, Архангай, Хөвсгөл, Төв зэрэг аймгуудад тус бүр 2, Сэлэнгэ, Сүхбаатар, Говь-Алтай, Увс, Баянхонгор, Дундговь, Хэнтий зэрэг аймгуудад тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант улиралд гадаадын хөрөнгө оруулалттай Жи Си Ай Пи, Фиананс энд девелопмент оф майнинг, Монголиагонконг финанс корпораци зэрэг ХХК-нд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай ББСБ-уудын тоо 16 болсон нь нийт ББСБ-ын 11.3 хувийг, тэдгээрийн нийт актив 16,786.8 сая төгрөгт хүрсэн нь ББСБ-ын нийт активын 23.9 хувийг тус тус эзэлж байгаа үзүүлэлттэй байна.

Дээрх ББСБ-уудыг харьяалалаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1 /*Зөн сан Монгол*/, гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 15 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь Япон улсын хөрөнгө оруулалттай 3 /*Тэнхлэг финанс, Марико, Сар шинэ интернейшил*/, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хөрөнгө оруулалттай 2 /*Санкредит, Ийст Уэст факторинг*/, БНХАУ, БНСУ, ОХУ-ын болон Италийн 100 хувийн ба хамтарсан хөрөнгө оруулалттай 10 /*Грасслэнд, Футур эволюшн, Би И Ай*/ ББСБ үйл ажиллагаа явуулж байна. /*Хавсралт 2*

Мөн ББСБ-ууд Монгол улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциатай хамтран хэрэгжүүлж буй Тогтвортой амьжиргаа төслийн

Бичил санхүүгийн хөгжлийн сан, Япон улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах сангийн Гэр хорооллын нөхцөлийг сайжруулах, Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан зэрэг хөтөлбөр, төслүүд бичил санхүүгийн байгууллагуудаар дамжин нийгмийн эмзэг бүлгүүдийн өрхийн орлого болон ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллаж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан боловч үйл ажиллагаа явуулж эхлээгүй болон 2007 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангаа ирүүлээгүй Кредит лизинг, Альфа кредит, Монголын валютын төв бирж, Афин, Ундрах, Дархан сайхан булаг, Ханбуурал кредит, Цэцэрлэг-Ар, Хануй сан, Материал лизинг, Монголтхан инвест, Тэргүүн хөгжлийн хөтөч, Цагаан Ажнай, Инвест кредит, Монгол лизинг зэрэг нийт 16 ББСБ-уудыг нэгтгэлд хамруулсан нь нийт ББСБ-уудын 11.3 хувийг эзэлж байна. Дээрх ББСБ-уудын санхүүгийн тайланг өмнөх улирлуудаар болон эхлэлтийн тэнцэлээр нэгтгэлд хамрууллаа.

Түүнчлэн санхүүгийн бодит мэдээлэл гаргах зорилгоор дээрх 16 ББСБ-уудын үзүүлэлтүүдийг хасч тооцон, санхүүгийн тайлангаа журамд заасны дагуу ирүүлсэн 125 ББСБ-уудын тайланг нэгтгэн тохируулан тооцоолов.

Тайлант улиралд Улаанбаатар хот, орон нутаг дахь ББСБ-ын нийт салбар, нэгжийн тоо 62 болсон байна.

Тайлант оны эцэст ББСБ-уудын нийт хувь нийлүүлэгчдийн тоо 447, нийт ажиллагсдын тоо 640 гаруйд хүрчээ. Мөн давхардсан тоогоор 40.0 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Судалгаанаас үзэхэд ББСБ-уудын олгож буй зээлийн хүүгийн түвшин дундажаар 2.0-3.5 хувь, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрт төлж буй хүүгийн түвшин дундажаар 0.5-2.0 хувь байна.

ХОЁР. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2.1 Ашигт ажиллагааны талаар

ББСБ-ууд тайлант хугацаанд нийт 1,052.2 /*тохируулсан тэнцэлээр 1,020.6*/ сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад /*өмнөх оны мөн үеийн цэвэр ашиг 446.8 сая төгрөг*/ 2.4 / *тохируулсан тэнцэлээр 2.3*/ дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь ББСБ-уудын үйл ажиллагааны цар хүрээ өсч, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэр нэмэгдэн, санхүүгийн зуучлалын хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор нийт орлого өссөнтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, нийт орлогын өсөлтийн хурдац нийт зардлын өсөлтийн хурдацаас их байгааг харуулж байна.

Тайлант хугацаанд тодорхой хэмжээгээр ашигтай ажилласан 110 ББСБ байгаа нь нийт ББСБ-ын 78.0 хувийг эзэлж байгаа ба тэдгээрийн ашиг 0.03 мянган төгрөгөөс 170.2 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Жишээлбэл, Транскапитал /*170.2 сая төгрөг*/, Дельта сан /*164.9 сая төгрөг*/, Кредит монгол /*130.5 сая төгрөг*/ зэрэг ББСБ-ууд харьцангуй өндөр ашигтай ажилласан нь эдгээр ББСБ-уудын үйл ажиллагаа тогтворжиж, бичил санхүүгийн зах зээлд байр сууриа нэгэнт олсон, удирдлагын менежмент сайн, зээлийн оновчтой үйл ажиллагаа хэрэгжүүлж буй болон боловсон хүчин чадварлаг байгаатай холбоотой.

Харин 24 ББСБ буюу нэгтгэлд хамрагдсан нийт ББСБ-уудын 17.0 хувь нь алдагдалтай ажилласан байна. Тухайлбал, Империаг гоулд /288.3 сая төгрөг/, Зөн сан Монгол /102.3 сая төгрөг/, Би энд Жи финанс /56.4 сая төгрөг/ зэрэг ББСБ-ууд алдагдалтай ажиллажээ.

Алдагдалтай ажиллаж байгаа зарим шалтгааныг нь тодруулж авч үзвэл, эрхэлж буй үйл ажиллагааны онцлог болон үйл ажиллагааны зардал өндөр /Зөн сан Монгол ББСБ/, зээлийн чанар муудсанаар эрсдлийн зардал өндөр байгаа /Би энд Жи финанс ББСБ/, орлогын өсөлт зардлын өсөлтөөс бага /Өрнөх инвест ББСБ/, үйл ажиллагаа жигдрээгүй /Очир тигэм ББСБ/ зэргээс шалтгаалжээ.

ББСБ-ууд нийт 1,385.2 сая төгрөгийн ашгийг хуримтлуулан тооцсон ба тухайн үеийн ашигтай ажилласан нийт 110 ББСБ-уудын арифметик дундаж ашиг 9.6 сая төгрөг байна.

2.2 Нийт орлогын бүтцийн талаар

Нийт орлого тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс /өмнөх оны мөн үед нийт орлого 4,610.3 сая төгрөг/ 26.8 хувиар буюу 1,237.7 сая төгрөгөөр өсч 5,848,0 сая төгрөгт хүрсэн нь нийт эх үүсвэр, түүний дотор санхүүгийн бусад үүсвэр өмнөх оны мөн үеэс 2 дахин буюу 9,780.9 сая төгрөгөөр нэмэгдсэнээр хүүгийн орлого авчирдаг актив 24,776.8-30,472.7 сая төгрөг болж өссөнөөс шалтгаалжээ.

Нийт орлогын 68.2 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байгаа нь ББСБ-уудын хувьд зээлийн үйл ажиллагааны орлого нь нийт орлогын гол эх үүсвэр болсоор байгаа нь ББСБ-уудын эрхлэх үйл ажиллагааны нэр төрөл, цар хүрээ хязгаарлагдмал байгааг харуулж байна.

2.3 Нийт зардлын бүтцийн талаар

Нийт зардал өмнөх оны мөн үеэс зээлийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжсөн, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор зардал зүйл тус бүрээр өсч 4,795.9 сая төгрөгт хүрч /өмнөх оны мөн үед нийт зардал 4,163.5 сая төгрөг/, нийт зардал өмнөх оны мөн үеэс 15.0 хувиар буюу 632.4 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт зардлын өсөлтийн шалтгаан нь нэгдүгээрт, ББСБ-уудад итгэлцлийн үйлчилгээгээр санхүүгийн эх үүсвэр бусдаас татан төвлөрүүлж байгаа, банк, санхүүгийн байгууллагаас зээл авах хандлага нэмэгдсэн, дамжуулан зээлдүүлэх төсөлд хамрагдах ББСБ-уудын тоо өссөн зэрэг обьектив хүчин зүйлээс шалтгаалж хүүгийн зардал өссөн, хоёрдугаарт, үйлчилгээний цар хүрээ өргөжсөн болон ББСБ-уудын механик тоон өсөлттэй холбоотойгоор үйл ажиллагааны болон боловсон хүчинтэй холбоотой зардал нэмэгдсэн, гуравдугаарт, зээл болон зээлтэй адилтган тооцох активын хэмжээ нэмэгдсэн, активын чанар муудаж байгаагаас эрсдлийн зардал өссөн зэрэгтэй холбоотой байна.

Мөн ББСБ-уудын нийт ашиг өссөнтэй холбоотойгоор 179.7 сая төгрөгийн татварын зардал гарсан байна.

ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Активын өөрчлөлтийн талаар

ББСБ-уудын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

№	Үзүүлэлт	2006.06.30		2007.06.30	
		Дүн	Хувь	Дүн	Хувь
А	Эргэлтийн хөрөнгө	51,984,341.3	92.7%	58,186,284.6	82.7%
1	Мөнгөн хөрөнгө	18,699,169.2	28.6 %	17,820,937.0	25.3 %
2	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт	4,141,622.0	7.4 %	4,205,500.1	6.0 %
3	Зээл /цэврээр/	24,776,822.9	44.6 %	30,472,749.8	43.3 %
4	Санхүүгийн түрээсийн болон факторингийн тооцооны авлага /цэврээр/	554,292.1	1.0 %	802,750.8	1.5 %
5	Эрсдлийн сангууд	1,125,499.6	2.1 %	1,271,647.8	1.4 %
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	600,874.5	1.1 %	909,816.2	1.3 %
7	Авлага /цэврээр/	749,166.4	1.3 %	159,116.4	0.2 %
8	Бусад актив	3,211,559.2	5.8 %	3,727,109.1	5.3 %
Б	Эргэлтийн бус хөрөнгө	3,625,223.1	6.5%	12,162,987.1	17.3%
8	Үндсэн хөрөнгө (цэврээр)	3,476,118.3	6.3 %	11,870,034.9	16.9 %
9	Өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	150,104.8	0.2 %	292,952.3	0.4 %
НИЙТ АКТИВ		55,610,564.4	100%	70,349,271.7	100%

Тайлант хугацаанд нийт эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт актив өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар буюу 14,738.7 сая төгрөгөөр өсч 70,349.3 сая төгрөг болсон ба нийт активын бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна.

Тухайлбал, нийт эх үүсвэр нэмэгдсэнээр хүүгийн орлого авчирдаг активуудын дүн 25,331.1-31,275.5 сая төгрөг болж өссөн ч хурдац нь нийт активын өсөлтийн хурдацаас бага байгаагаас нийт активт эзлэх хувийн жин нь 45.6-44.8 хувь болж буурсан, харин ББСБ-ууд үндсэн хөрөнгө их хэмжээгээр нэмж бэлтгэсэнтэй холбоотойгоор эргэлтийн бус хөрөнгийн дүн өсч нийт активт эзлэх хувийн жин 6.5-17.3 хувь болж өссөн байна.

3.2 Активын багцын чанар

ББСБ-уудын нийт эх үүсвэр нэмэгдсэнээр зээл, түүнтэй адилтгах актив /хүүгийн орлого авчирдаг актив/ 31,275.5 сая төгрөгт хүрсэн нь нийт активын 44.8 хувийг эзэлж байна. Энэ нь банкны салбарын нийт олгосон зээлийн 1.8 орчим хувьтай тэнцэж байна.

Зээл, түүнтэй адилтгах активын бүтэц дараах байдалтай байна. Үүнд, хэвийн зээл, түүнтэй адилтгах актив нийт зээл, түүнтэй адилтгах активын багцын 91.9 хувь /29,843.0 сая төгрөг/, хугацаа хэтэрсэн зээл 3.2 хувь /1,026.0 сая төгрөг/, хэвийн бус 1.5 хувь /492.3 сая төгрөг/, эргэлзээтэй болон муу зээл 1.7 /566,5 сая төгрөг, 554,4 са төгрөг/ хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад активын чанарт дараах өөрчлөлтүүд орсон байна. Нийт зээл, түүнтэй адилтгах активын өсөлтөөс хэвийн зээл болон муу зээл, тэдгээртэй адилтгах активын өсөлт их байгаагаас нийт зээл, түүнтэй адилтгах активт эзлэх хувийн жин 91.9-93.0, 1.7-2.6 хувь болж тус тус өссөн байна.

Ихэнх ББСБ-ууд эрсдлийн санг 2004 оны 459/207 тоот Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан тушаалаар шинэчлэн батлагдсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу байгуулсан байна.

3.3 Активын төвлөрлийн эрсдэл

Монгол улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг ББСБ-ууд хангаж ажиллаж байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТАЛААР

4.1 Нийт эх үүсвэрийн өөрчлөлтийн талаар

ББСБ-уудын тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	2006.06.30		2007.06.30	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
Санхүүгийн бусад эх үүсвэр	9,280,949.5	16.7 %	19,061,817.1	27.1 %
Банк, ББСБ-аас авсан зээл	3,865,965.8	7.0 %	12,928,314.5	18.4 %
Бусад эх үүсвэрийн данс /итгэлцэл, факторинг, мөнгөн гуйвуулга/	3,228,151.9	5.8 %	3,240,758.3	4.6 %
Төслийн зээлийн санхүүжилт	2,144,314.0	3.9 %	2,855,668.4	4.1 %
Бусад өр төлбөр	1,959,714.3	3.5 %	3,310,366.7	4.7 %
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	128,957.4	0.2 %	138,244.3	0.2 %
Бусад пассив	1,830,756.9	2.9 %	3,172,122.3	4.5 %
Нийт өр төлбөр	11,240,663.8	20.3 %	22,372,183.7	31.8 %
Өөрийн хөрөнгө	44,369,900.5	79.8 %	47,977,087.9	68.2 %
Ердийн хувьцаа	40,090,789.8	72.1 %	42,712,841.0	60.7 %
Давуу эрхтэй хувьцаа	570,011.8	1.0 %	163,020.1	0.2 %
Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	1,339,500.8	2.4 %	1,204,346.8	1.7 %
Нөөцийн сан	922,122.7	1.7 %	1,039,702.4	1.5 %
Нийгмийн хөгжлийн сан	42,391.9	0.1 %	38,153.6	0.1 %
Тухайн үеийн ашиг /алдагдал	446,834.7	0.8 %	1,052,151.0	1.5 %
Хуримтлагдсан ашиг/алдагдал	707,425.0	1.3 %	1,385,205.4	2.0 %
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	55,610,564.4	100.0 %	70,349,271.7	100 %

Тайлант хугацаанд нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 26.5 хувь буюу 14,738.7 сая төгрөгөөр өсч 70,349.3 сая төгрөгт хүрсэн нь ББСБ-уудын банкнаас авсан зээлийн хэмжээ 2.0 дахин буюу 9,780.9 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт эх үүсвэрийн бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал, өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдац нийт эх үүсвэрийн өсөлтийн хурдацаас бага байгаагаас өөрийн хөрөнгийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 79.8-68.2 хувь болж буурсан, харин бусад пассивын нийт нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 29.-4.5 хувь болж өссөн.

Нийт эх үүсвэрийн 68.2 хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлж байгаа нь нэг талаас Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу ББСБ нь зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхэлнэ гэсэнтэй нийцэж байгаа, нөгөө талаас бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх явц нь зохистой түвшинд байгааг харуулж байна.

4.2 Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын үйл ажиллагаа өргөжиж, ашиг нэмэгдэж буйтай холбоотойгоор ББСБ-уудын нийт өөрийн хөрөнгө 47,977.1 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.0 хувиар буюу 3,607.2 сая төгрөгөөр өссөн байна.

Эрсдэлтэй активын өсөлтөөс шалтгаалж эрсдлээр жигнэсэн нийт активын хэмжээ 37,032.2-52,528.3 сая төгрөг болж өссөн, өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдац, эрсдлээр жигнэсэн активын өсөлтийн хурдацаас бага байгаа зэргээс шалтгаалж нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө нийт цэвэршүүлсэн активын харьцаа 87.9 хувь, өөрийн хөрөнгө нийт цэвэршүүлсэн активын харьцаа 91.3 хувь байгаа нь Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох тухай журам"-д заасан зохистой харьцааны үзүүлэлтийг ББСБ-ы н нэгдсэн нэгтгэлийн хувьд хангаж ажилласан байна.

4.3 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт

ББСБ-ууд бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх замаар нийт эх үүсвэрээ нэмэгдүүлснээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 19,985.0 сая төгрөг, харин түргэн борлогдох актив 17,820.9 сая төгрөг байгаагаас ТТГЧ-ын шалгуур үзүүлэлт нэгтгэлээр 89.1 хувь байгаа нь журамд заасан хязгаарлалтыг хангаж байна. Гэвч ТТГЧ-ын үзүүлэлтийг санхүүгийн бусад эх үүсвэрийг их хэмжээгээр татан төвлөрүүлж буй, ялангуяа итгэлцлийн үйл ажиллагаа явуулж буй ББСБ хангахгүй байх эрсдэл үүсэх хандлагатай байна.

Түргэн борлогдох активын бүтцийг судлахад 68.8 орчим хувь буюу 12,254.2 сая төгрөг нь бэлэн мөнгө, бусад хувь нь банк болон бусад санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл байна.

Харин бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 13.8 хувь буюу 2,755.1 сая төгрөг нь итгэлцлийн үйлчилгээний өглөг, 59.9 хувь буюу 11,968.9 сая төгрөг нь банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, үлдсэн хувь нь зарим эх үүсвэр, бусад пассив эзэлж байна.

ТАВ. ГАДААД ВАЛЮТЫН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант хугацааны эцэст гадаад валютын позици нэгж болон нийт валютаар 21.0 хувь байгаа нь журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг нэгтгэлээр болон дийлэнх ББСБ-уудын хувьд хангаж байгаа ч гадаад валютын ханшийн эрсдлээс

сэргийлэх зорилгоор гадаад валютаар зээл олгох сонирхол давамгайлснаар уг үзүүлэлтийг хангахгүй байх эрсдэл ББСБ-уудад үүсч байна.

Гадаад валютаар олгосон зээл, санхүүгийн түрээс болон факторингийн авлагын үлдэгдэл 10,994.6 сая төгрөг байгаа нь нийт хүүгийн орлого олдог активын багцын /31,275.5 сая төгрөг/ 35.2 хувийг, харин нийт бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрийн /19,061.8 сая төгрөг/ 12.2 хувийг гадаад валютаар бүрдүүлсэн байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

ББСБ-уудын нийт актив 2007 оны хагас жилийн байдлаар 70,349.3 сая төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт активын 2.6 хувьтай тэнцэж байгаа ба нийт активын өгөөж 3.53 /ROA/ хувь байна. Харин өөрийн хөрөнгө 47,977.1 сая төгрөгт хүрсэн нь нийт банкны системийн 15.0 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн өгөөж 4.48 /ROE/ хувь байна.

ББСБ-уудын хувьд зөвхөн өөрийн хөрөнгөөр төдийгүй бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх замаар үйл ажиллагаагаа өргөтгөхийн тулд банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, төсөлд хамрагдах, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх сонирхол өсч байгаагаас нийт эх үүсвэрийн хэмжээ цаашид өсөх хандлагатай байна. Энэ нь хэдийгээр санхүүгийн зуучлалыг нэмэгдүүлж буй боловч хүлээж болзошгүй эрсдэл үүсэх, нэмэгдэх, цаашлаад санхүүгийн хямралыг үүсгэж болзошгүй юм. Цаашид санхүүгийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, санхүүгийн зуучлалыг өргөжүүлэх, шударга өрсөлдөөнт орчныг бий болгох асуудлыг төрөөс зохицуулснаар, санхүүгийн зуучлалыг олон улсын стандартын дагуу сонгодог утгаар нь гүнзгийрүүлэн хөгжүүлэх, санхүүгийн салбар дахь эрсдлийг бууруулах юм.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР